

Юан (Юань 元 yuán) гэдэг нэрийн учир

Б.Сумьяабаатар (Монгол)

Яахаараа, Чингис хааны ач хүү Хубилай өөрийн улсын нэрийг Юан гэж нэрлэх болов? Монгол нэр байгаагүй юм уу, олдоогүй юм уу, хаан суугаад цөөхөн жил өнгөрөхөд, улсдаа монгол нэр өгч чадахааргүй болтлоо монголоо умартсан, хятаджисан хүн байсан юм уу (Хубилай хятад хэлтэй байсан ч юм уу, үгүй ч юм уу, улсдаа 大元 Dà-Yuán, Да-Юан гэсэн нэр өгөх цагт лав л хятад хэл сурч амжаагүй байсан), дэргэд нь олон арван монгол эрдэмтэн мэргэд байсан, тэд нар юу бодож сэтгэж байсан юм бол? Бүгд монголоо мартсан, усан толгойтнууд байлаа гэж үү? гэх зэрэг олон асуулт шил шилээ даран гарч ирнэ. Эгээ ч үгүй байлгүй, энд нэг л учир бий. Асуудлын ээдрээг тайлах нэг гогцоо нь 元 (нан. yuán) гэдэг ганц ханз (漢字) үсгийн утгад байгаа юм биш биз гэсэн бодлын үүднээс дэлгэрэнгүй задлан үзье:

元 (нан. yuán)

Хятад монгол тольд 1. тэргүүн, толгой, нэгдүгээр 2. эхи, уг, үндэс, язгуур, эхний, анхны 3. төгрөг 4. Юан улс (эртний) гэсэн байх ба

Солонгос хас толь(玉篇)д 1. тэргүүн, анх, эхний (始也) 2. их, агуу (大也) 3. толгой (首也) 4. том (長也) 5. улсын нэр (國名) 6. үндэс (原也) 7. овог (姓也) гэсэн байх ба

Солонгос хятад тольд 1. тэргүүн (原也) 2. энэрэнгүй, нигүүлсэнгүй (善良) 3. нигүүлсэнгүй хүн (善人) 4. оны эхний өдөр (元旦 шинийн

нэгэн) 5. оны цол (年號) 6. толгой (頭首) 7. хаан, эзэн (君也)
8. иргэн (民也) 9. их (大也) 10. хий, хүч (氣也) 11. тэнгэр (天也)
12. урт (長也) гэх мэт бөгөөд,

Япон хас тольд 1. 本也 2. 始也 3. 一也 4. 首也 5. 長也 6. 君也 7. 大也 8. 善也
9. 天子之元子 士也 10. 元吉 11. 上也 12. 天也 13. 氣也 14. 民也
15. 時間一單位 16. 賣 17. 諡 18. 年號 19. 朝代名 20. 原也 21. 玄
(通玄) 聖祖仁皇帝(康嚙帝)廟諱曰玄燁一玄用. 元代. 之 22. 百六韻 一
23. 姓 24. 貨幣單位 гэсэн 24 утга жагсаасан байх бөгөөд
(973–974–р тал),

Хятад хэлний их тольд 1. 始也 端也 2. 首也 頭也 3. 本也 原也 4. 一也 5. 長也 首長也
6. 君也 7. 正嫡也 8. 大也 9. 善也 10. 美也 11. 上也 12. 天也
13. 賣也 14. 天地之大德 氣也 15. 百姓 16. 時間單位 17. 諡也
18. 年號 19. 朝代名 20. 原也 21. 玄 (通玄) 清聖祖諱玄燁玄用
元代之 22. 百六韻之一 23. 姓 24. 貨幣名 мэт 25 утга
жагсаасан байх бөгөөд (318–319–р тал),

Үгийн далай (辭海 –гийн хулгана дэвтэр 子集 ийн 284–р талд) 1. 始也 2. 長也 首也
3. 大也 4. 善也 5. 朝代名 6. 通原 通原
7. 通玄 清時... 改玄爲元 ... гэх мэт
утга гаргажээ.

元 (нан. yuán) ыг улсын нэр болгоёо гэвэл, "Тэргүүн, Эхний, Анхны, Агуу, Их, Тэнгэр, Тэнгэр Газрын их эрдэм, хүч" гэх мэт Хаан хүнд эс таашаагдах утга 元 (нан. yuán)д үгүй байна. Гэхдээ л түүний цаана хятад санаа агуулагдан, орчуулж бодно уу гэхээс бус, монгол сэтгэхүй биш нь тодорхой.

Алив улсад, өөрсдийнх нь нэрлэдэг нэр, өрөөл бусад түүнийг нэрлэдэг нэр гэж буйг үгүйсгэх учиргүй ч, 元 (нан. yuán) нь нэн ялангуяа монгол хүний байгуулсан, Монгол улсын нэрнээ огт зохимжгүй санагдана.

Тэгвэл, монгол хүнд таалагдах, дотроо давхар санаад байх өөр утга 元 (нан. yuán)д байна уу гэж ухаж үзвэл, байна аа! Тэгэх мөртөө тэр нь, монголчуудын ихэд эрхэмлэдэг, "Хөх Тэнгэр", "Хөх Монгол" гэдэгт ордог "Хөх" гэсэн утга 元 (нан. yuán)д байна. Энэ нь ойр зуурын, бага, дунд гарын тольд үгүй. Хятад хэлний "Үгийн далай 辭海" хэмээх Их толь(7-р утгыг үз), "Хятад хэлний Их толь" (Тайванд хэвлэсэн. 21-р утгыг үз), "Япон Хас толь"(21-р утгыг үз)нуудад байна.

元 (yuán) нь 玄 (хөх, тэнгэр өнгө)тэй ижил утгатай (元通玄) гээд, Юаны үед тийн хэрэглэж байсан гэсэн тайлбартайгаа байна, үүнд:

21. 玄 (通玄) 清聖祖諱玄燁玄用元代之

21. 玄 (通玄) 聖祖仁皇帝(康熾帝)廟諱曰玄燁一玄用.元代.之

7. 通玄 清時... 改玄爲元

гэж бичжээ.

Энэ утга бидэнд тун чухал. 元通玄 гэсэн нь 元 (yuán) нь 玄 (xuán)тэй ижил утгатай гэсэн үг. 玄 (xuán) нь тэнгэр, тэнгэрийн өнгийг заадаг. Дээрхийн нуталгаа болгож өөр нэг жишээ татая:

Монгол Улсын Төв номын санд ганц хувь байдаг "Шинээр орчуулсан Мянган үсгийн соён " (Mikgea foisoitoo Soyoo) буюу 千字文—д

天地元黃 гэж тэнгэрийн өнгийг 元 (yuán)аар бичээд, түүнийгээ

"Тэнгэр ХӨХ, Газар шар Dekri Kiket Geje* Si* t гэж орчуулсан байдаг.

Солонгос "Мянган үсгийн соён"д ижил утгатай 玄 (xuán) ийг нь

хэрэглэж 天地玄黃 천지현황 гэсэн байдаг нь бидний өгүүлээд байгаа зүйлийн давхар баталгаа болж байна.

Ийнхүү үзэхэд, хятад ба монгол хүн Юан улсын нэрийг дор дороо өөр өөрийнхөөрөө ойлгоод байсан байж таарлаа.

Хятадууд нь болохоор 元 (нан. yuán)ыхаа нангиад утгыг санаад, монголчууд нь болохоор 元 (yuán)ы "Хөх" (Хөх Монгол) гэсэн монгол утгыг бодоод улсын нэрийг өгчээ.

Тэр цагийн хүмүүс 元 (yuán) гэдэг үсэгт "Хөх" гэсэн утга байдаг гэдгийг сайтар мэддэг байсан. Харин сүүл үеийнхэн л 元 (yuán) гэдэг үсгийн "Хөх" (Хөх Монгол) гэсэн утгыг гүүрч ойлгохгүй, тийм утгатай байсан гэдгийг мэдэхгүйн улмаас өөрийн улсын нэрийг хятад маягаар нь хуулан "Юань" (Юан), "Юань улс", "Их Юань улс" гэх мэтээр хэлж ярьж, бичиж зуршсан байна. Энэ мэт 元 (нан. yuán)ы ард "Хөх" (Хөх Монгол) гэсэн санаа давхар агуулагдаж байснаас улбаалан яргуулан бодвол,

"Юань улс" гэдгийн монгол нэр нь "Хөх Монгол" ;

"Юаны Нууц Түүх" (元秘史 yuán-mì-sh – Нууц Товчооны анх нэр) маань "Хөх (Хөх Монголын) Нууц Түүх" гэсэн утгатай байсан болж таарна.

Монголын Нууц Товчооны 203–р зүйлийн 382–р мөрнөө гардаг

"Хөх дэвтэр" (闊闊迭卜帖兒 нангиадаар 青冊 гэж орчуулсан буй) ;

Инжаннаштаны Их Юан улсын мандсан төрийн "Хөх судар" ч цаанаа маш нарийн утга учиртай болох нь тодорхой байна.

Эцэг хөвүүд – Их бичгийн мэргэд 元 (нан. yuán) гэдэг үгнээ "Хөх" гэсэн утга буйг юу эс андах билээ! Тийм ч учраас, үе залгамжлан туурвисан алдарт бүтээлээ "Хөх Судар" гэж нэрлэсэн байнам.

Орчин цагт Инжаннашийн "Хөх Судар"-ыг нангиадаар 蒙古青史 гэж орчуулдаг нь "Монголын Хөх түүх" гэсэн үг. Гэхдээ ханз нь 青 ба 元 гэсэн ялгаатай. 元史 гэж орчуулбал, Юан улсын нэртэй хутгалдаад байж магадгүй учир зайсаж, мөн нийтэд ойлгомжтойг бодож 青史 гэж орчуулах болсон бололтой

Мөн, Юаньши (元史) ийг хятад хүний зохиол гэх боловч, мэдээж монгол мэргэд эрхбиш оролцсон байж таараа. Түүнийг "Юань улсын судар" гэж орчуулдаг боловч, мөн л "Юаны түүх", "Хөх түүх" гэсэн санаа давхар байхыг үгүйсгэшгүй.